



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/168/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дорноговь аймаг 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий	
	Утас: 70522734	Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn
	Аудитын менежер: У.Оюунтүлхүүр	
	Утас: 70523020	Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
	Ахлах аудитор: Э.Энхцэцэг	
		Цахим хаяг: enkhtsetsege@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2022.04.28 № 1-6/213

танай _____ -ны № _____ -т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ч.ЭНХМЭНД ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.ГАН-ӨЛЗИЙ

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	<u>12,008,289,083.07</u>	<u>12,640,315,354.19</u>
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	<u>429,740,397.07</u>	<u>402,665,225.52</u>
	Нийт хөрөнгийн дүн	<u>12,438,029,480.14</u>	<u>13,042,980,579.71</u>
	Нийт өр төлбөрийн дүн	<u>142,289,309.62</u>	<u>118,454,796.60</u>
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<u>12,295,740,170.52</u>	<u>12,924,525,783.11</u>
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<u>12,438,029,480.14</u>	<u>13,042,980,579.71</u>
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	<u>68,029,588,919.99</u>	<u>67,501,869,248.88</u>
	Үйл ажиллагааны зардлын дүн	<u>62,360,626,426.99</u>	<u>66,869,703,149.56</u>
	Үйл ажиллагааны үр дүн	<u>5,668,962,493.00</u>	<u>632,166,099.32</u>
	Үйл ажиллагааны бус үр дүн		2,381,071.33
	Үйл ажиллагааны нийт үр дүн	<u>5,668,962,493.00</u>	<u>634,547,170.65</u>
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл		
	Тайлант оны үр дүн		634,547,170.65
	Эцсийн үлдэгдэл		12,924,525,783.12
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	<u>63,742,441,040.35</u>	<u>65,844,712,843.44</u>
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	<u>62,681,494,232.51</u>	<u>66,905,429,659.83</u>
	Үйл ажиллагааны ЦМГ	<u>1,060,946,807.84</u>	<u>-1,060,716,816.39</u>
	Хөрөнгө оруулалтын ЦМГ		
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	1,060,946,807.84	-1,060,716,816.39
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		54,861,175,362.42
	Урсгал зардал		54,861,175,362.42
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		44,240,223,689.66
	Улсын төсвөөс санхүүжих		72,500,800.00
	НДС-аас санхүүжих		44,124,613,586.09
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		43,109,303.57

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна.

Эрхэм зорилго: Бид даатгуулагчийнхаа итгэл найдвар сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэнэ.

Алсын хараа: Нийгмийн даатгалын байгууллага нь даатгуулагчдад тохиолдсон эрсдэлийг зөөлрүүлэх, даатгуулагч төвтэй бие даасан даатгалын үндэсний мэргэшсэн чадварлаг, ил тод нээлттэй, ёс зүйг дээдэлсэн манлайлагч байгууллага болох.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

Ковид-19 цар тахал өвчинтэй холбоотой “Нийгмийн даатгалын тухай хуулиудыг дагаж хэрэглэх журам”-ын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2019.12.20-ны өдрийн хуулиар тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг 2021 оноос эхлэн 9.5 хувь байхаар заасны дагуу ажил олгогч, албан журмын даатгуулагч тэтгэврийн даатгалд тус бүр 9.5 хувиар тооцож шимтгэл төлөхөөр тогтоосон.

Иймд 2021 оны 1 дүгээр сараас эхлэн ажил олгогч нийгмийн даатгалын таван төрөлд нийт хөдөлмөрийн хөлсний сан түүнтэй адилтгах орлогоос үйл ажиллагааны чиглэлээс хамааран 13.5, 14.5, 15.5 хувиар, албан журмын даатгуулагч 12.5 хувиар төлөхөөр тогтоосон.

УИХ-ын чуулганаар 2021.07.01-ээс хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогоос төлөх тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг тус бүр 8.5 хувь байхаар өөрчлөн тогтоосон.

НДШ-ээс чөлөөлөх ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуульд хамрагдсан аж ахуйн нэгж байгууллага, түүнд ажиллаж байгаа Монгол улсын иргэн даатгуулагч нь 2021.01.01-ний өдрөөс 2021.07.01-ний өдөр хүртэлх хугацаанд төлөх тэтгэмж, ажилгүйдэл, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын шимтгэлээс бүрэн, тэтгэврийн даатгалын шимтгэлийн ажил олгогч болон даатгуулагчийн төлөх 1.0 хувиас тус тус чөлөөлөгдөж, тэтгэврийн даатгалын шимтгэлийг ажил олгогч, даатгуулагч тус бүр 8.5 хувиар тооцон төлөхөөр, харин 2021.07.01-ний өдрөөс эхлэн эдгээр ажил олгогч, даатгуулагч НДШ-ийг хуульд заасан хувь хэмжээгээр төлөхөөр зохицуулсан байна.

Гурав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй. Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш орлогын 142,678.0 сая төгрөгийн 3,791, зарлагын 145,673.3 сая төгрөгийн 3,721 ажил гүйлгээ, зардал зарцуулах тухай 28 тушаалыг бүрэн мэдээлсэн байна.

Дөрөв. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн үндсэн хөрөнгийн бүртгэлд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 57 нэрийн, 175.3 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байх бөгөөд тус хөрөнгүүдэд шинээр үнэлгээ тогтоон цаашид ашиглах талаар асуудлыг шийдвэрлүүлэх, энэ асуудлыг дараагийн аудитаар авч үзэх.

Тав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

6.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Дорноговь аймгийн НДХэлтэс	1	1	-	-	1	-	-	-
НИЙТ									

6.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

[illegible]